ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ДГА-2023/61/НА-СТА-ТШЗ**

---

<table>
<tr>
<td>Цахим хуудас:<br>www.dornogovi@audit.gov.mn<br><br>Сайншанд сум<br><br>2022 он</td>
<td>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий<br><br>Утас: 261665, 70522734<br>Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: У.Оюунтүлхүүр<br>Утас:70523020<br>Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn<br><br>Аудитор: Т.Оюунтуяа<br>Утас: 99048991<br>Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn</td>
</tr>
</table>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.24 № 1-6/218

танай ______ -ны № ______ -т

ХҮНС, ХӨДӨӨ, АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГА
Ж.НАРАНБОЛД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаж, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Илрүүлэлтээр Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 271.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 232.3 сая төгрөгийн 11 гүйлгээ, 6.7 сая төгрөгийн 9 шийдвэрийг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 3.5 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо

0100^04^0

хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Малын дансны үнэ бодит бус илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйл Нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах; 20.2.9.аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 9 зорилт, 25 арга хэмжээний хэрэгжилт 99.3 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.6 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **50,296,601.49** | **46,558,979.99** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 3,431,114.00 | 5,263,354.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 3,431,114.00 | 5,263,354.00 |
| **3121** | **Төгрөг** | 3,431,114.00 | 5,263,354.00 |
| 31218 | Ахмадын сангийн харилцах | 3,431,114.00 | 5,263,354.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 7,200,000.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 7,200,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 39,665,487.49 | 41,295,625.99 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,984,664.27 | 9,079,529.77 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,984,664.27 | 9,079,529.77 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,437,823.22 | 28,360,096.22 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,094,134.00 | 979,134.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 23,909,589.22 | 23,898,362.22 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,231,500.00 | 3,403,600.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 202,600.00 | 79,000.00 |
| 35600 | Мал амьтад | 4,243,000.00 | 3,856,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **226,482,192.87** | **234,380,779.43** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 226,482,192.87 | 234,380,779.43 |
| **392** | **Биет хөрөнгө** | 160,505,193.07 | 169,833,779.51 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 149,744,234.50 | 149,744,234.50 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (43,837,619.32) | (61,990,262.20) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 89,200,000.00 | 76,050,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (52,556,250.00) | (31,971,527.78) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 38,562,569.88 | 45,262,094.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (30,456,024.16) | (16,368,650.71) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,935,967.80 | 11,541,029.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (8,234,858.96) | (4,982,225.69) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 43,610,383.08 | 41,042,418.88 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (38,463,209.75) | (38,493,331.19) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 65,976,999.80 | 64,546,999.92 |
| 39301 | Програм хангамж | 7,008,145.00 | 7,008,145.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,783,145.20) | (5,213,145.08) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 62,752,000.00 | 62,752,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **276,778,794.36** | **280,939,759.42** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **276,778,794.36** | **280,939,759.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 276,778,794.36 | 280,939,759.42 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 829,485,493.11 | 829,485,493.11 |
| 51101 | Өмч: - төрийн | 829,485,493.11 | 829,485,493.11 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (637,189,563.72) | (662,267,331.19) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (593,111,234.24) | (666,428,296.25) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (44,078,329.48) | 4,160,965.06 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 84,482,864.97 | 113,721,597.50 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **276,778,794.36** | **280,939,759.42** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **315,442,626.50** | **328,635,970.50** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,656,714.50** | 67,765,570.50 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,656,714.50 | 67,765,570.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,656,714.50 | 4,158,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,246,500.00 | 4,158,000.00 |
| 120009 | Бусад орлого | | 29,377,175.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 16,274,400.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | | 17,955,995.50 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 308,785,912.00 | 260,870,400.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 292,308,700.00 | 254,860,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 292,308,700.00 | 254,860,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,477,212.00 | 6,009,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 62,040.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,415,172.00 | 6,009,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **359,520,955.98** | **311,786,101.44** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **359,520,955.98** | **311,786,101.44** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 352,477,722.98 | 298,969,872.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 198,436,760.00 | 193,907,912.00 |
| 210101 | Үндсэн цалин | 149,324,960.00 | 150,225,116.00 |
| 210102 | Нэмэгдэл | 40,225,800.00 | 26,947,567.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,886,000.00 | 11,785,514.00 |
| 210104 | Урамшуулал | - | 4,949,715.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,359,140.00 | 25,397,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,443,140.00 | 17,338,194.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,979,000.00 | 2,026,125.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,583,200.00 | 1,614,160.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 395,800.00 | 401,720.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,958,000.00 | 4,016,901.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,927,400.00 | 11,467,150.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,251,206.00 | 1,033,320.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,001,938.00 | 9,053,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 674,256.00 | 1,380,830.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,141,964.50 | 9,771,966.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,451,124.50 | 2,357,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,283,100.00 | 4,566,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,606,300.00 | 1,711,050.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 106,900.00 | 144,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,265,540.00 | 992,716.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,429,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,044,950.00 | 1,908,644.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,044,950.00 | 1,908,644.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,492,000.00 | 2,037,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,492,000.00 | 2,037,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 40,942,358.00 | 12,997,158.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 35,603,791.00 | 3,324,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,188,000.00 | 1,598,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,220.00 | 131,420.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 120,000.00 | 54,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,600,000.00 | 7,740,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 95,347.00 | 148,538.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 54,133,150.48 | 41,482,442.44 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,812,110.00 | 5,278,454.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 48,321,040.48 | 36,203,988.44 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,043,233.00 | 12,816,229.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,484,300.00 | 1,929,882.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,484,300.00 | 1,929,882.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 10,886,347.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 10,886,347.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,558,933.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,558,933.00 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(44,078,329.48)** | **16,849,869.06** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 12,688,904.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 12,688,904.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (12,688,904.00) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(44,078,329.48)** | **4,160,965.06** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **313,032,412.00** | **271,370,648.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,246,500.00** | **4,158,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,246,500.00 | 4,158,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 4,246,500.00 | 4,158,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,246,500.00 | 4,158,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **308,785,912.00** | **267,212,648.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 292,308,700.00 | 254,860,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 292,308,700.00 | 254,860,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 16,477,212.00 | 12,352,048.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 62,040.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 16,415,172.00 | 12,352,048.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **314,354,250.00** | **269,538,408.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **314,354,250.00** | **269,538,408.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **306,523,917.00** | **256,722,179.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 198,079,500.00 | 197,077,934.00 |
| 210101 | Үндсэн цалин | 148,967,700.00 | 153,395,138.00 |
| 210102 | Нэмэгдэл | 40,225,800.00 | 26,947,567.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,886,000.00 | 11,785,514.00 |
| 210104 | Урамшуулал | - | 4,949,715.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,716,400.00 | 25,397,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,800,400.00 | 17,270,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,979,000.00 | 2,031,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,583,200.00 | 1,625,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 395,800.00 | 406,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,958,000.00 | 4,063,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,927,400.00 | 11,467,150.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,251,206.00 | 1,033,320.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,001,938.00 | 9,053,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 674,256.00 | 1,380,830.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,489,205.00 | 5,195,538.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 843,700.00 | 680,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,451,000.00 | 2,199,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,606,300.00 | 1,711,050.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 106,900.00 | 144,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,481,305.00 | 460,888.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 570,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 570,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,020,294.00 | 2,389,945.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 180,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 3,840,294.00 | 2,389,945.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,492,000.00 | 2,037,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,492,000.00 | 2,037,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 54,350,358.00 | 8,572,358.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41,811,791.00 | 6,100,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 240,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,188,000.00 | 1,598,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,220.00 | 131,420.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 120,000.00 | 54,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,800,000.00 | 540,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 95,347.00 | 148,538.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,878,760.00 | 4,584,654.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,878,760.00 | 4,584,654.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **7,830,333.00** | **12,816,229.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,271,400.00 | 1,929,882.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,271,400.00 | 1,929,882.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,558,933.00 | 10,886,347.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,558,933.00 | 10,886,347.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(1,321,838.00)** | **1,832,240.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (1,321,838.00) | 1,832,240.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 4,752,952.00 | 3,431,114.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 3,431,114.00 | 5,263,354.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 829,485,493.11 | 84,482,864.97 | -619,307,144.60 | 294,661,213.48 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **829,485,493.11** | **84,482,864.97** | **-619,307,144.60** | 294,661,213.48 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 26,195,910.36 | 26,195,910.36 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **829,485,493.11** | **84,482,864.97** | **-593,111,234.24** | 320,857,123.84 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **829,485,493.11** | **84,482,864.97** | **-593,111,234.24** | 320,857,123.84 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -29,238,732.53 | -29,238,732.53 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **829,485,493.11** | **84,482,864.97** | **-622,349,966.77** | 291,618,391.31 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 29,238,732.53 | 0.00 | 29,238,732.53 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 4,160,965.06 | 4,160,965.06 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **829,485,493.11** | **113,721,597.50** | **-618,189,001.71** | 325,018,088.90 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 254,860,600.00 | 252,642,261.00 | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 254,860,600.00 | 252,642,261.00 | 2,218,339.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 254,257,700.00 | 250,712,379.00 | 3,545,321.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 199,519,600.00 | 197,077,934.00 | 2,441,666.00 |
| 210101 | Үндсэн цалин | 158,501,100.00 | 153,395,138.00 | 5,105,962.00 |
| 210102 | Нэмэгдэл | 24,618,000.00 | 26,947,567.00 | (2,329,567.00) |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,785,300.00 | 11,785,514.00 | (214.00) |
| 210104 | Урамшуулал | 4,615,200.00 | 4,949,715.00 | (334,515.00) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 25,397,100.00 | 25,397,100.00 | - |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,270,000.00 | 17,270,000.00 | - |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,031,800.00 | 2,031,800.00 | - |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,625,400.00 | 1,625,400.00 | - |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 406,400.00 | 406,400.00 | - |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,063,500.00 | 4,063,500.00 | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,465,900.00 | 11,467,150.00 | 998,750.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,079,200.00 | 1,033,320.00 | 45,880.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,932,100.00 | 9,053,000.00 | 879,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,454,600.00 | 1,380,830.00 | 73,770.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,264,500.00 | 5,195,538.00 | 68,962.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 680,600.00 | 680,600.00 | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,199,000.00 | 2,199,000.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,780,000.00 | 1,711,050.00 | 68,950.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 144,000.00 | 144,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 460,900.00 | 460,888.00 | 12.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,390,100.00 | 2,389,945.00 | 155.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,390,100.00 | 2,389,945.00 | 155.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,041,300.00 | 2,037,500.00 | 3,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,041,300.00 | 2,037,500.00 | 3,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,098,800.00 | 4,072,358.00 | 26,442.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,600,000.00 | 1,600,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,598,400.00 | 1,598,400.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 156,900.00 | 131,420.00 | 25,480.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 54,000.00 | 54,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 540,000.00 | 540,000.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 149,500.00 | 148,538.00 | 962.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,080,400.00 | 3,074,854.00 | 5,546.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,080,400.00 | 3,074,854.00 | 5,546.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 602,900.00 | 1,929,882.00 | (1,326,982.00) |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 602,900.00 | 1,929,882.00 | (1,326,982.00) |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 602,900.00 | 1,929,882.00 | (1,326,982.00) |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 254,860,600.00 | 254,474,501.00 | 386,099.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 254,860,600.00 | 247,146,479.00 | 7,714,121.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 254,860,600.00 | 247,146,479.00 | 7,714,121.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 7,328,022.00 | (7,328,022.00) |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 7,328,022.00 | (7,328,022.00) |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 3,431,114.00 | (3,431,114.00) |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 5,263,354.00 | (5,263,354.00) |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 20.00 | 17.00 | 3.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | - |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 19.00 | 16.00 | 3.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 11.00 | 4.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3.00 | 4.00 | (1.00) |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **9,182,026.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **9,182,026.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 9,182,026.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,500,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,509,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,509,800.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 3,172,226.00 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 3,172,226.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 9,182,026.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,182,026.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,182,026.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35.5 сая төгрөгийн 3 алдаа[1] илэрснээс аудитын явцад 35.5 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа.

**Залруулсан алдаа:**

1. Улсын төсвийн данснаас ахмадын сангийн дансанд шилжүүлсэн 3.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэснийг залруулсан;
2. Анхан шатны баримтын тулгалтаар 10 харилцагчаас 3.1 сая төгрөгийн цахим төлбөрийн баримт аваагүй байсныг нөхөж шивүүлсэн;
3. Дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг 29.2 сая төгрөгөөр илүү бүртгэснийг тус тус залрууллаа.

Аудитаар нийт 2 зөрчил[2] илэрснээс 2 зөвлөмж өгсөн.

### 3.3 Зөвлөмж

### 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 271.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 232.3 сая төгрөгийн 11 гүйлгээ, 6.7 сая төгрөгийн 9 шийдвэрийг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 3.5 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансанд холбогдох мэдээллүүдийг тогтоосон хугацаанд үнэн зөв, бүрэн оруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

### 2. Хөрөнгийн бодит үнэ цэнтэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Малын дансны үнэ бодит бус үнээр илэрхийлэгдсэн байна. Энэ нь хөрөнгөнд тавих хяналт суларснаас хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, дутагдах үр дагавартай.

Мөн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйл Нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах; 20.2.9.аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; гэсэн заалтуудтай нийцэхгүй ба үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Холбогдох хуулийн заалтуудыг мөрдөж ажиллах, хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэх.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Улсын төсвийн данснаас ахмадын сангийн дансанд шилжүүлсэн 3.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэсэн. | 1 | 3,170.0 | 0 | - | 1 | 3,170.0 | 1 | 3,170.0 | 0 | - | | |
| Анхан шатны баримтын тулгалтаар 10 харилцагчаас 3.1 сая төгрөгийн цахим төлбөрийн баримт аваагүй. | 1 | 3,057.7 | 0 | - | 1 | 3,057.7 | 1 | 3,057.7 | 0 | - | | |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг 29.2 сая төгрөгөөр илүү бүртгэсэн. | 1 | 29,238.7 | | | 1 | 29,238.7 | 1 | 29,238.7 | | | | |
| **Дүн** | **3** | **35,466.4** | **-** | **-** | **3** | **35,466.4** | **3** | **35,466.4** | **0** | **-** | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Малын дансны үнэ бодит бус илэрхийлэгдсэн байна. | 1 | | | | - | - | 1 | | | | | |
| **Дүн** | 1 | | | | - | - | 1 | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 271.6 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 232.3 сая төгрөгийн 11 гүйлгээ, 6.7 сая төгрөгийн 9 шийдвэрийг хугацаа хоцроосон, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 3.5 сая төгрөгийн 8 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. | 1 | | - | - | | - | 1 | |
| Дүн | 1 | | - | - | | - | 1 | |